

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН СУДЛАГДАХУУН

А.Муратхан

*Шинжлэх ухааны гавьяат
зүтгэлтэн, доктор (Ph.D),
профессор, хурандаа*

Х.Асхар

*Дотоод хэргийн их сургууль,
Хилийн албаны сургуулийн Хилийн
боомтын аюулгүй байдал, шалган
нэвтрүүлэх албаны тэнхимийн
профессор, доктор (Ph.D),
хурандаа*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д шинээр нэмэгдэж орсон “хилийн аюулгүй байдал” гэсэн томъёоллын үндэслэл, түүнийг гадаадын зарим оронд яаж ойлгох, хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт түүний илрэх хэлбэр, тэдгээрийг судалдаг хил судлалын шинжлэх ухааны энэ талаарх бүрдэл хэсэг, хилийн аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын чиглэл зэргийг тайлбарлан оруулсан болно.

Түлхүүр үгс: хилийн аюулгүй байдал, эрсдэл, ашиг сонирхол, тогтолцоо, хилийн орон зай, хил орчмын нутаг дэвсгэр.

Удиртгал

Монголын ард түмэн улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,

хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс түүх соёлынхоо өв уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан байгуулахыг эрхэм зорилго (Legalinfo, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 1992) болгон үндсэн хуулиар хуульчилсан билээ.

Үндсэн хэсэг

Олон улсын харилцааны шинж чанар, уур амьсгал нааштайгаар өөрчлөгдсөн хэдий ч аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрэлдэн бий болоогүй, улс болоод ашиг сонирхлын бүлэглэлүүдийн хооронд зөрчил, сөргөлдөөн үргэлжилсээр байгааг Орос-Украйн, Израйл-Хамасын хоорондын зэвсэгт мөргөлдөөн нотлон харуулж байна. Эдгээр олон улс болон бүс нутгийн хэмжээнд үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангаж, үндэсний язгуур эрх ашгаа урьтал болгосон, тогтвортой хөгжлийн асуудлаа шийдвэрлэх бие даасан бодлого, үйл ажиллагаа явуулах шаардлага тулгарч байна.

Дэлхийн улс гүрнүүд нийгмийн хөгжлийн жам ёсоор харилцаа холбоогоо бэхжүүлж байгаа боловч үндсэрхэг үзэл газар авч, үндэстэн ястан, шашин хоорондын зөрчил, мөргөлдөөн,

геополитикийн болон гео эдийн засгийн ашиг сонирхлын өрсөлдөөн гарсаар байна.

Монгол Улсын оршин тогтносон 2200 гаруй жилийн хугацаанд нутаг дэвсгэр хил, хязгаарын төлөө явуулсан тэмцлийн түүхээс харахад түүнд тал бүрээс учирч байсан аюул занал нь түүнийг хүн төрөлхтний түүхийн тавцангаас зайлуулах, нутаг дэвсгэрийг нь эзэмших, эс чадваас хил орчмын тодорхой газар нутгийг тасалж авах зорилго, чиглэлтэй явагдаж иржээ.

Хүн ам цөөн, газар нутаг өргөн уудам, нийгэм эдийн засгийн хөгжлөөр харьцангуй сул манай улсын хувьд өөрийн аюулгүй байдлыг хангахад нэн түрүүнд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх явдал юм гэдгийг өнгөрсөн үеийн түүхэн сургамж харуулж байна. 80 гаруй жилийн өмнө Японы милитаристуудын зүгээс Халхын голын чиглэлээр өдөөсөн дайны зорилго нь Монголын талаас эзэмшилгүй байсан хил орчмын газар нутгийг цэргийн хүчээр эзэмших, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн болон хилийн аюулгүй байдалд ноцтой нөхөж баршгүй хохирол учруулахын төлөө явагдсаныг бид мартаагүй байна.

Өнөөдөр хөдөөгийн хүн амын ихэнх нь төв рүүгээ нүүдэллэж олонх нь нийслэлд амьдрах болсноор хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйрч байна. Судалгаагаар Монгол Улс нийт 3 сая 457 мянга 548 хүн амтай,

үүний 45 орчим хувь буюу улсын нийслэл Улаанбаатар хотод 1,591,375 иргэн амьдарч байна. (ИОМ, 2022)

Экологийн нөхцөл байдалд нүүрлэж буй цөлжилт говийн бүсийг төдийгүй тал хээр, ойт хээрийн бүс нутгийг хамарч байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж, хилийн дагуу асар уудам газар нутаг эзэнгүйрч улсын хил хамгаалалтад шууд нөлөөлөх болов.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” гэж заасны дагуу зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай улсын хилийн асуудлыг XX зууны сүүлийн хагаст бүрэн шийдвэрлэж, баталгаажилтыг нь хүлээн зөвшөөрснөөр олон улсын эрх

зүйн үндэс бүрдсэн байна. Цаашид тогтоон тэмдэглэж, баталгаажсан хилийг өөрчлөхгүй, зөрчилгүй, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн манах, хамгаалах ажиллагааг улам боловсронгуй болгох нь манай хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг мөн.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (улсын хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол хамгаалагдсан байх нөхцөлийг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог байна.

Тиймдээ ч Монгол Улсын хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д *“хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ”, “хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн”* (Legalinfo, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2016) гэж заасан нь зарим гадаад улсын томъёололд нийцэж байна.

Дүгнэлт

Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичигт “Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл

ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ” гэж заасан. Энэ нь хилийн аюулгүй байдлыг агуулгын хувьд бүрэн хамарч чадаагүй байжээ гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн” (Legalinfo, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2016) гэж заасан боловч, энэ талаар тусгайлан судлагдаагүй, түүнийг хангах онол, арга зүй болон ямар арга хэмжээ авах үндэслэл, аргачлал одоогоор боловсрогдоогүй, эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Монгол Улсын хил хамгаалах байгууллага нь хилийн тухай хуулийн дагуу хилийн орон зай /улсын хил, хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэр/-д үйл ажиллагаа явуулж байгаа боловч тэнд хилийн аюулгүй байдлыг хангах, тэрхүү орон зайг хамгаалах, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөлийг хэрхэн, яаж баталгаатай хангах талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй, энэ талаар хийгдсэн цогц судалгаа одоогоор байхгүй байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тэр дундаа хилийн аюулгүй байдлыг хангах

гадаад, дотоод таатай орчин бүрдэж байгаа боловч улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, түүнд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг багасгах нь чухал байна.

Улсын хил нь нэгэнт хоёр улсын нутаг дэвсгэрийн зааг болохоор тус тусын нутаг дэвсгэр, ялангуяа хил орчмын нутаг дэвсгэр дээрх амьдрал үйл ажиллагаа, эд баялгийн ашиглалт нь тухайн улсын эрх мэдэлд хамаарагдана.

Чухам хилийн аюулгүй байдал гэдэг нь юу болохыг ойлгохын тулд улс оронд тулгарч байсан түүхэн болон тулгарч байгаа өнөөгийн аюул заналыг ухамсарлан ойлгох зайлшгүй шаардлагатай юм.

Аль ч улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон хилийн аюулгүй байдлыг хэрхэн, яаж ойлгож байгаа талаар тодорхой түвшинд нэгтгэсэн ойлголт ховор бөгөөд зарим судлаачид хилийн аюулгүй байдлыг цэргийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт оруулж иржээ.

Эх сурвалж

ИОМ. (2022). *Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага*. Улаанбаатар. Legalinfo. (1992 оны 01 13). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Монгол Улсын Үндсэн хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367-ээс> Гаргасан Legalinfo. (2002 оны 05 16). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Төрөөс хилийн талаар баримтлах

бодлого:

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=6493-ээс> Гаргасан Legalinfo. (2010). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6163-ээс> Гаргасан Legalinfo. (2016 оны 12 28). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Монгол Улсын хилийн тухай хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12418-ээс> Гаргасан zakon.kz, О. (с изменениями и дополнениями 2024 оны январь 05). *Юрист*. Электронное правительство: https://online.zakon.kz/Document/?doc_id=31320511&pos=2;-106#pos=2;-106-ээс Гаргасан Арвай, Ш. (2013). *Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам*. Улаанбаатар: Мөнхий үсэг ХХК. портал, и. (2008 оны 07 21). *Государственной Пограничной комитет Республики Беларусь*. О Государственной границе Республики Беларусь: <https://gpk.gov.by/zakonodatelstvo/laws/-ээс> Гаргасан фонд, Э. (с изменениями на 2022 года оны ноябрь 04). *Электронный фонд правовых и нормативно-технических документов*. О Государственной границе Российской Федерации: <https://docs.cntd.ru/document/9033575-ээс> Гаргасан